



**ХАЛДВАРТ ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/203

Улаанбаатар хот

**Хүүхэд хамгааллын журам
батлах тухай**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 24 дүгээр зүйл, 30 дугаар зүйлийн 30.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр хэсгийн 1, 2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Журам батлах тухай" А/240 дугаар тушаал, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн хүүхэд хамгааллын журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмыг нийт ажилтанд танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг алба, тасгийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Батлагдсан журмыг дагаж мөрдөхийг төвийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

4.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (М.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



С. ЭНХБОЛД

Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн ерөнхий захирлын 2025 оны
12 дугаар сарын 20-ний өдрийн
Халдварт өвчин судлалын үндэсний төвийн
дугаар тушаалын хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү журмаар халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүүхэд хамгаалал болон байгууллагын байгууллагын ажилтны хүүхэд хамгааллын үйлчилгээг зохицуулна.
- 1.2 Төвийн бүх салбар нэгжийн ажилчид холбогдох бусад хууль, дүрэм, журамд нийцүүлэн энэхүү журмыг баримтална.
- 1.3 Энэхүү журмыг байгууллагын бүх ажилтан, гэрээт ажилтан, резидент эмч, дадлагажигч, сайн дурын ажилтан, оюунтан гэх мэт эрүүл төвийн нэрийн өмнөөс ажиллаж буй бүх хүн мөрдөж ажиллана.

ХОЁР. ҮНДСЭН ЗАРЧИМ

- 2.1 Хүүхдийг хүндэтгэх, эрх ашгийг дээдлэх: хүүхдийн язгуур эрх, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавин хэнийг ч, хэдийд ч, хаана ч үл ялгаварлан, тэгш хандан, хүүхэд, гэр бүлийн хувийн нууцыг чанд хадгална.
- 2.2 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг огт зөвшөөрөхгүй: хамт олон, эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр хүүхдийн эсрэг хүчирхийллийн аливаа хэлбэртэй үл эвлэрнэ. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх үүргээ ухамсарлан ажил үүргээ хэрэгжүүлэх болон амьдралын өдөр тутмын уйл ажиллагаанд хүүхдэд эрсдэл учруулахаас сэрэмжлэх, хүүхдэд эерэг харилцаа, хандлагыг эрхэмлэхийг ажилтан бүрээс шаардана;
- 2.3 Хүүхдэд хор хөнөөл учруулахгүй байх: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь хүүхдийг ямар нэг дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, ялгаварлан гадуурхагдах байдалд үл хүргэх, хүчирхийллийн аливаа нэгэн дарамтад орсон эсэхийг нягтлан сэрэмжлэх ёс зүйн хандлагад суурилна;
- 2.4 Эрсдэлийг үнэлэх, сэргийлэх, мэдээлэх: Үйл ажиллагаандаа хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах байдалд оруулж болзошгүй аливаа эрсдэл байгаа эсэхийг судалж, эрсдэлийг бууруулах, мэдээлэх замаар хор нөлөөг багасгахад байнга анхаарч хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй үзүүлнэ;
- 2.5 Энэрэнгүй байх: Хүүхдийн өвчин, зовуурь, шаналгаа, биеийн болон сэтгэл зүйн дарамт, бухимдал байгаа эсэхийг мэдрэн ойлгож, чин сэтгэлээсээ туслахын төлөө эрмэлзэх.

ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээ

3.1.1 Халдварт өвчин судлалын үндэсний төв нь Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн нас, хөгжлийн онцлог, тусгай хэрэгцээ, суурь өвчлөл, өвчний явц, хүнд, хөнгөнд нийцүүлэн эцэг эх, асран хамгаалагчийн санал, хүүхдээ асрах чадавхад үндэслэн хүүхдэд тусламж, үйлчилгээг шуурхай, ээлтэй байдлыг эрхэмлэн үзүүлэх;

3.1.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр хүүхдэд учирч болзошгүй хүчирхийллийн аливаа хэлбэрийг үнэлэх, илрүүлэх, зохих ажилтанд мэдээлэх мэдлэгтэй байх;

3.1.3 Хүүхдэд харилцааны зөв үлгэр дуурайлал үзүүлэх, тэдэнтэй хүндэтгэлтэй харилцах, итгэлийг нь хүлээх, хувийн нууцыг нь хадгалж, хамгаалах;

3.1.4 Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ асран хамгаалагч болон хүүхдийн хэрэгцээ, чадварт нь тохируулан тэдний санал, хүсэлтийг сонсон, урьдчилж тайлбарлах, мэдээлэл өгөх, зөвлөх, сэтгэл зүйн айдас, түгшүүр үүсгэхгүй байх;

3.1.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд нэн даруй мэдээлнэ

3.1.6 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр хүүхдийн аюулгүй байдлыг хянан хүүхдийн эсрэг хүчирхийллийн шинж байдлыг илрүүлэх, хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, мөлжлөг, хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн, зөрчсөн байж болзошгүй үйлдлийн талаар байгууллагын удирдлага, эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдлын алба, хүний нөөцийн алба, шаардлагатай бол хүүхдийн тусламжийн утас 108 болон цагдаагийн байгууллагад заавал мэдээлэх, хариу арга хэмжээг цаг алдалгүй авах, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах;

3.1.7 Төвийн эрх бүхий албан тушаалтан хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэн хариу өгөх, бусад талд уламжлан хамтран шийдвэрлүүлэх;

3.1.8 Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнийг тогтмол сурган чадавхжуулах;

3.1.9 Эрүүл мэндийн болон хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ шаардлагатай гэр бүл, эцэг эх, хүүхдэд туслах арга хэмжээ авах;

3.1.10 Хүүхэд хамгааллын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэл бууруулах, гомдол, мэдээлэл хүлээн авах талаарх мэдээллийг ил тод, харагдах орчинд байрлуулж, тогтмол сурталчлах;

3.1.11 Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх орчны аюулгүй байдлыг хангаж, шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх, түүнд хяналт тогтоох;

- Нярай, бага насны хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийг унахаас сэргийлсэн хамгаалалт бүхий ор, хүүхдийн суултуур, гарын угаалтуур зэрэг тэдний нас, хөгжилд тохирсон, ээлтэй орчныг бүрдүүлэх,
- Тусгай хэрэгцээтэй хүүхэд, 5 хүртэлх насны хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ сахиуртай байлгах, шаардлагатай бол дохионы хэлмэрч зэргийг дуудах, байлцуулах.

3.1.12 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад хүүхдийг дахин хохирохоос хамгаалж бүх мэдээллийн нууцыг хангах, хүчирхийллийн хохирогч эсвэл гэрч хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг зохих дүрэм, журмын дагуу шуурхай, үр дүнтэй үзүүлэх нөхцөлийг хангаж хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх;

3.1.13 Төв нь Хүүхдийн эсрэг зөрчил гаргасан эсвэл энэхүү журмын хэм хэмжээг биелүүлээгүй ажилтны мэдээлэл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэн, хариу өгч, хяналт тавих, холбогдох байгууллагад шилжүүлэх;

3.1.14 Эрүүл мэндийн байгууллага эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд харьяалал харгалзахгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээг гэр бүлийн хүчирхийллийн болон гэмт хэргийн хохирогч хүүхдэд харьяалал, дараалал харгалзахгүйгээр шууд үзүүлнэ.

3.1.15 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад мэдсэн хүүхэд, түүний гэр бүлийн гишүүний хүний хувийн болон эмзэг мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан шаардсанаас бусад тохиолдолд бусдад дамжуулах, мэдээлэхийг хориглоно.

3.1.16 Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдэд Хөдөлмөрийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн хөнгөн ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, аюултай, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэд өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх;

3.2 ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭН, АЖИЛТНЫ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

3.2.1 Нийт эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан болон шинээр ажилд томилогдсон албан хаагчдад хүүхэд хамгааллын журмыг танилцуулан баталгаажуулах;

3.2.3 Төвийн удирдах ажилтан, албан тушаалтны төлөөлөл бүхий эцэг эхийн зөвлөл байгуулан, хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээний хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.4 Эцэг эхийн зөвлөл нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ажиллагсдын хүүхдийн эрүүл мэнд, эрхийг хамгаалах, нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг зохион байгуулах,
- Байгууллагын ажиллагсдын хүүхдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд туслах арга хэмжээг зохион байгуулах,
- Зохион байгуулсан арга хэмжээг эцэг эх болон холбогдох байгууллагад мэдээлэх, тайлагнах,
-

3.2.5 Төвийн ажилтан сонгон шалгаруулах журамд хүүхэд хамгааллын шалгуурыг тусгах, тухайлбал хүүхэдтэй зүй бусаар харилцаж байсан эсэх талаар зан байдлын тодорхойлолт, лавлагаа гаргуулах;

3.2.6 Хүүхдийн өрөөтэй байх;

3.2.7 Ээлжээр ажилладаг эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны хүүхдийн аюулгүй байдлыг хангах, байгууллагын харьяанд хүүхэд харах үйлчилгээг хэрэгжүүлэх;

3.2.8 Нийгмийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрх, хүүхдэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.9 Ажилтанд хүүхдээ зөв зохистой асран хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхийг даалгах, эцэг эхийн үүргийг дэмжин туслах, тулгамдсан хэрэгцээтэй үед нь гэр бүл, хүүхдийн эрхийн мэдээлэл, сургалт, зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх талуудад холбон зуучлах;

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

4.1 Халдварт өвчний дэгдэлтийн болон гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг хязгаарлах, зогсоох шийдвэр гаргахыг хориглоно.

4.2 Халдварт өвчний дэгдэлт, гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг боломжит арга, хэлбэрээр хүргэхэд төвийн бүх ажилтан туслалцаа үзүүлнэ.

4.3 Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны зүгээс хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм зөрчихийг хориглоно.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1 Энэхүү журмын 4.3-д заасан хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.